

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТЭС

ИЛТГЭХ ХУУДАС

“Таныг сонсьё” аяныг зохион байгуулсан тухай

2019.12.11

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээг шинэ шатанд гаргаж, шийдвэр гаргах түвшинд иргэд, оршин суугчдын саналыг тусган хотын хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтын ажилд тэдний оролцоог нэмэгдүүлэх, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангах зорилгоор 2019 оныг “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил” болгосонтой холбогдуулан Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь “Байгууллагын хөгжил-Үйлчилгээний чанар”-ын жил болгон зарлаж, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.


Зорилтод жилийн хүрээнд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагааг сурталчилах, дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, хэрэглэгчдийн санал хүсэлтийг нээлттэйгээр хүлээн авч, хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор газарын даргын 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр баталсан удирдамжийн дагуу “Таныг сонсьё” аяныг 2 дахь жилдээ зохион байгууллаа. Тус аяныг 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 06-ны өдрийн хугацаанд зохион байгуулсан бөгөөд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгууллагын танилцуулга, аяны тухай мэдээллийг шторк хэлбэрээр бэлтгэж, НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудад нийтийн эзэмшлийн талбайд байрлах дэлгэцээр тогтмол хугацааны давтамжтайгаар явууллаа.



Зураг 1. Байгууллагын танилцуулга явагдаж байгаа байдал

- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн системд “Таныг сонсьё” аянд идэвхтэй оролцож, цахим судалгаанд саналаа өгөхийг уриалсан мэдээлэл байршуулсан. Тус мэдээллийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдаас 86 дэмжиж, 27 сэтгэгдэл үлдээсэн байлаа.



Зураг 2. ERP системд байршуулсан мэдээлэл

- Үйлчилгээний алба, Байр ашиглалтын албаны ажилтнууд байгууллагын лого бүхий “Таныг сонсьё” аяныг илтгэсэн таних тэмдгийг зүүж, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн санал хүсэлтийг нээлттэйгээр хүлээн авч, холбогдох албан хаагчид танилцуулж, богино хугацаанд шийдвэрлүүлж ажилласан.



Зураг 3. Үйлчилгээний ажилтнууд “Таныг сонсьё” аяны энэрийн тэмдэг зүүсэн байгаа нь

- НЗЗ-ын байрууд, НҮНТ-ийн салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг цахим хэлбэрээр авсан.

Нэгтгэсэн хүснэгт

Хүснэгт 1

Асуултууд	НЗЗ-ны байр, НҮНТ-ийн салбарууд										Нийлбэр
	1-р байр	2-р байр	3-р байр	4-р байр	5-р байр "А"	5-р байр "Б" "В"	НҮНТ-ийн Мишээл салбар	НҮНТ-ийн Дунжингара в салбар	НҮНТ-ийн Драгон салбар	НҮНТ-ийн Оргил салбар	
Цэвэрлэгээ, үйлчилгээний чиглэлээр											
1. Таны ажиллаж буй өрөө, тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээ хангалттай явагдаж байгаа эсэх?											
Сайн	46	212	54	61	3	20	30	67	29		522
Дунд	13	66	29	13		9		2	7		139
Хангалтгүй	2	10	5	4		1					22
2. Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ хангалттай явагдаж байгаа эсэх?											
Сайн	48	198	50	61	3	23	29	68	33		513
Дунд	10	81	33	14		6	1	1	3		149
Хангалтгүй	2	5	4	3		1					15
3. Таны ажиллаж буй байр, давхарын ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ хангалттай явагдаж байгаа эсэх?											
Сайн	40	178	50	58	3	22	30	67	31		479
Дунд	17	90	29	14		7		2	5		164
Хангалтгүй	4	17	8	5		1					35
Байр ашиглалтын чиглэлээр											
1. Таны ажиллаж буй байр, давхрын цахилгаан, ус, ариун цэврийн өрөөний хэвийн, найдвартай ажиллаж байгаа эсэх?											
Сайн		166	55	56	3	20					300
Дунд		98	27	17	3	6					151
Хангалтгүй		18	5	5		4					32
2. Цахилгаан, сантехник, мужаан, холбооны дуудлагын үйлчилгээ танд түргэн шуурхай хүрдэг эсэх?											
Сайн		184	48	59		19	28	57	34		429
Дунд		83	38	15		9	2	10	1		158
Хангалтгүй		11	0	3		1			1		16
3. Хурлын заалны тоног төхөөрөмж шаардлага хангаж байна уу?											
Сайн		203				13					216
Дунд		67				10					77
Хангалтгүй		4				7					11
Зоогийн үйлчилгээний чиглэлээр											
1. Зоогийн газрын хоолны нэр төрөл, амт чанар таны сэтгэлд нийцэж байгаа эсэх?											
Сайн	33	84									117
Дунд	20	141			1						162
Хангалтгүй	7	50			2						59
2. Зоогийн газрын үйлчилгээний ажилтны харилцаа, үйлчилгээнд сэтгэл хангалуун байдаг эсэх?											
Сайн	35	156			2						193
Дунд	16	101			1						118
Хангалтгүй	8	17									25
Эмчийн үйлчилгээний чиглэлээр											
1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ чанартай хүрч чадаж байгаа эсэх?											
Сайн	46										46
Дунд	10										10
Хангалтгүй	3										3

2. Их эмч, сувилагчийн харилцаа, үйлчилгээнд сэтгэл хангалуун байдаг уу?										
Сайн	54									54
Дунд	4									4
Хангалтгүй	1									1

Нэгтгэсэн дүн /графикаар/





График 1. Цэвэрлэгээ үйлчилгээний талаар санал асуулгын дүн



График 2. Байр ашиглалтын чиглэлээр санал асуулгын дүн





График 3. Зоог, цайны газрын үйлчилгээний чиглэлээр санал асуулгын дүн



График 4. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чиглэлээр санал асуулгын дүн

НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын үнэлгээний харьцуулалт /коэффициент/






График 5. Цэвэрлэгээ, үйлчилгээний чиглэлээр НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын а.х-ын өгсөн үнэлгээний харьцуулалт







График 6. Байр ашиглалтын чиглэлээр НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын а.х-ын өгсөн үнэлгээний харьцуулалт





График 7. Зоог, цайны газрын үйлчилгээний чиглэлээр НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын а.х-ын өгсөн үнэлгээний харьцуулалт

Санал асуулгад ороцсон ажилтан албан хаагчдаас зарим санал хүсэлт:

НЗЗ-ны 1-р байр:

- Цайны газрын ажилтын харилцаанд анхаарах,
- Цайны газрын хоолны чанарт анхаарах,
- 00-ын цэвэрлэгээг сайжруулах,
- Эрэгтэй ариун цэврийн өрөөний суултуурыг босоо болгож солих,

НЗЗ-ны 2-р байр

- Хангарди ордны гадаа явган хүний зам гаргах,
- Хурлын заалны захиалга, мэдээллийг ERP системд холбох,
- Лифтны хүрэлцээ муу,
- Цахилгаан, мужаан, сантехникийн дуудлагыг түргэн шуурхай болгох
- Хоолны порц бага, үнэ өндөр байна,
- Хоолны үнэ өндөр,
- Хоолны нэр төрлийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах,
- Хоолыг эрт гаргадах болгох, өглөөний цайны хүрэлцээ муу,

НЗЗ-ны 3-р байр

- Зоорийн давхрын цахилгааны утас ил, замбараагүй байгааг цэгцлэх,
- 1-р давхарт цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол хийдэггүй,
- 00-ын өрөөний болон бусад цэвэрлэгээ, үйлчилгээг сайжруулах,

НЗЗ-ны 4-р байр

- Ажлын өрөө, тасалгаа хүйтэн,
- 7 давхарт тамхи татдаг,

НЗЗ-ны 5-р байр

- Үйлчлэгч нарын багаж хэрэгслийг сайжруулах,
- Хоолыг талонаар авдаг болох,
- Хоолны амт чанарыг сайжруулах, порцыг нэмэгдүүлэх,
- Ариун цэврийн өрөөнд шингэн саван байршуулах,
- Үүдний жижүүр орж, гарч байгаа хүмүүсийг бүртгэдэг болох,
- Хүйтэн байна.

НҮНТ-ийн Дүнжингарав салбар

- Ачаалал ихтэй үед уртасгасан цагаар ажиллах,
- Мужаан, цахилгаанчин дуудахад хурдан ирүүлдэг байх,

НҮНТ-ийн Драгон салбар

- Ажлын ширээг тогтмол арчуулах,

Дүгнэлт

“Таныг сонсьё” аянг 2018 оныхоос шинэлэг хэлбэрээр зохион байгуулсан ба НЗЗ-ны байруудад байрлаж байгаа нийт 39 байгууллагын болон НҮНТ-ийн салбаруудад ажиллаж байгаа 683 ажилтан, албан хаагчид оролцож санал хүсэлтээ өглөө. Санал асуулгыг НЗЗ-ны байруудад байрлаж байгаа ажилтан, албан хаагчдаас цахим хэлбэрээр, НҮНТ-ийн салбаруудад ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдаас цаасаар авч дүнг нэгтгэсэн.

1. Өрөө тасалгааны цэвэрлэгээ үйлчилгээнд сайн үнэлгээ өгсөн 522, дунд 139, хангалтгүй 22 үнэлгээг тус тус өгсөн байгаа нь цэвэрлэгээ үйлчилгээнд сэтгэл хангалуун байгааг харуулж байна. Байруудын харьцуулсан графикаас харахад НҮНТ-ийн Мишээл салбарт ажиллаж байгаа албан хаагчид хамгийн сэтгэл хангалуун байна.

2. Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, үйлчилгээнд сайн үнэлгээ өгсөн 513, дунд 149, хангалтгүй 15 үнэлгээг тус тус өгсөн байна. Харин НЗЗ-ны байрууд, НҮНТ-үүдийн санал өгсөн байдлыг харьцуулж харахад НҮНТ-ийн Дүнжингарав салбаруудад ажиллаж байгаа албан хаагчид хамгийн сэтгэл хангалуун байгаа нь харагдаж байна.

3. Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээний талаарх асуулгад сайн 479, дунд 164, хангалтгүй 35 үнэлгээг өгсөн ба ихэнх нь сайн үнэлгээ өгсөн боловч дунд үнэлгээ өссөн байгаа нь цаашид ариун цэврийн өрөөнүүдийн цэвэрлэгээнд анхаарах шаардлагатай байгааг харуулж байна. Байрууд болон НҮНТ-үүдийг харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны 1, 2, 3 дугаар байруудын ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээнд анхаарах шаардлагатай байна.

4. Инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагаанд сайн 300, дунд 151, хангалтгүй 32 үнэлгээг өгсөн байна. Харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны 2, 3, 5 дугаар байрны “Б”, “В” корпусуудын инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагаанд бусдаасаа доогуур үнэлгээ өгсөн байна.

5. Дуудлагын үйлчилгээний талаарх асуулгад сайн 429, дунд 158, хангалтгүй 16 гэсэн үнэлгээг тус тус өгсөн. Харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны 2, 3, 5 дугаар байрны “Б”, “В” корпусуудын дуудлагын үйлчилгээнд анхаарах шаардлагатай байна.

6. Зоогийн газрын үйл ажиллагаанд НЗЗ-ны 1, 2 дугаар байр, НЗЗ-ны 5 дугаар байрны “А” корпусын ажилтан албан хаагчид санал өгсөн бөгөөд хоолны нэр төрөл, амт чанарт сайн 117, дунд 162, хангалтгүй 59 гэсэн үнэлгээг тус тус өгсөн байгаа нь хоолны амт чанарт сэтгэл дундуур байна. Харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны 2, 5 дугаар байрны зоогийн газар, хоолны газрын нэр төрөл, амт чанарт анхаарах шаардлагатай байна.

7. Зоогийн газрын үйлчилгээний ажилтны харилцаа, үйлчилгээний талаарх асуултанд сайн 193, дунд 118, хангалтгүй 25 үнэлгээг тус тус өгсөн байгаа нь ажилтнуудын харилцаанд дийлэнх нь сэтгэл хангалуун байгааг харууллаа.

8. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд НЗЗ-ны 1-р байрны ажилтан, албан хаагчид санал өгсөн ба сайн 46, дунд 10, хангалтгүй 3 гэсэн үнэлгээ өгсөн байна.

9. Их эмч, сувилагчийн харилцаанд дийлэнхи нь сайн үнэлгээ өглөө.

10. Цэвэрлэгээ, үйлчилгээнд өгсөн үнэлгээ /дундаж/




График 8. Цэвэрлэгээ, үйлчилгээнд өгсөн үнэлгээний дундаж

11. Байр ашиглалтын чиглэлээр өгсөн үнэлгээ /дундаж/



График 9. Байр ашиглалтын чиглэлээр өгсөн үнэлгээний дундаж

12. Зоогийн үйлчилгээний чиглэлээр өгсөн үнэлгээ /дундаж/




График 10. Зоогийн үйлчилгээний чиглэлээр өгсөн үнэлгээний дундаж

13. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чиглэлээр өгсөн үнэлгээ /дундаж/




График 10. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чиглэлээр өгсөн үнэлгээний дундаж

14. Байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ




График 11. Байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

Судалгааны үр дүнд өгсөн дүгнэлтийн дагуу арга хэмжээ авч, НЗЗ-ны байрууд, НҮНТ-үүдэд ажиллаж байгаа албан хаагчдаас нээлттэй гаргасан санал хүсэлт, сэтгэл ханамжийн судалгаанд оролцсон төрийн албан хаагчдаас гаргасан санал, гомдолыг тус тус хүлээн авч судлан, шийдвэрлэж ажиллах болно.

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ